

**“МОНИНЖБАР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
2022 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Улаанбаатар хот

2023 оны 04 - р сарын 27

Хурал эхэлсэн цаг: 11.05

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан
3. 2023 оны зорилт, төлөвлөгөө
4. Ногдол ашгийн тухай

Хурлын явц:

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Нарантуяа хурлын дэгийг танилцуулав.
Хурлын дэгтэй холбоотой санал хэлэх хүн байна уу?
Хурлын дэгтэй холбоотой санал өгөх хүн **Байхгүй** хурлын дэгийг батлав.

ХЗБ комиссын дарга: Тооллогын комиссын даргаар О.Оюунжаргалыг сонгох саналтай байна, Та бүхэн саналаа хэлнэ үү?

Санал нэг байгаа тул Тооллогын комиссын даргаар О.Оюунжаргалыг томилохыг 100 хувийн саналаар зөвшөөрлөө. Тогтоол № 01-ийг уншиж танилцуулав.

Хурлын ирц: Хувьцаа эзэмшигчдийн хуралд ҮЦТХТ ХХК- иас 2023 оны 04 дугаар сарын 07-ны өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд багтсан нийт 11,610,350 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсон нь саналын эрхтэй нийт 15,869,233 ширхэг хувьцаанаас 73.16 % болсон тул хурал хүчин төгөлдөр болсон. Тооллогын комиссын тогтоолыг № 02 танилцуулав

Нийт хувьцааны тоо	15 869 233
Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн нэр	Хувьцааны тоо
Ц.Чингүүнболд	1824000
Ц.Оргилболд	912000
Б.Осолгүйгэрэл	30000
С.Баярцэцэг	6000
Б.Нарантуяа	4281920
Б.Цогтгэрэл	3548345
“БиДиСек ҮЦК” ХК	1008085
Нийт ирсэн нь	11610350
Нийт хувьцаанд эзлэх хувь	73.16 %

Б.Нарантуяа: За хурлын дэгийн дагуу хурлын даргыг сонгох ёстой, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Цогтгэрэлийг сонгох саналтай байна?

Эсрэг саналтай хүн гараагүй тул 100 хувийн саналаар Б.Цогтгэрэлийг ХЭХ-ын даргаар сонгов. Тогтоолыг № 03 уншиж танилцуулав.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлын дарааллаар Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа: "Улаанбаатар хотын тасганы усан сангаас 3,4-р хорооллын усан сан баруун дүүргийн насос станц хүртэлх 8070 метрийн урттай Ф600мм-ийн цэвэр ус дамжуулах гол шугамын барилга угсралтын ажил"-аас түншлэлийн хүрээнд нийт шугам угсралтыг суурилуулж дууссан ба туршилт тохируулга алдагдал олох ажлууд үлдээд байна. Энэхүү төслийн ажлыг 2017 оны үнэлгээгээр 5 дахь жилдээ сунган гүйцэтгэж байгаа нь алдагдал өсөх бодитой шалтгаан болсон. Гэрээний хугацаа сунгах үндсэн шалтгаанууд нь авто зам хуулж хийх зөвшөөрөл богино хугацаатай гардаг, газар чөлөөлөлт хугацаандаа хийгддэггүй зэрэг үндсэн шалтгаануудаас хамааралтай байдаг.

Зөвхөн энэ төслийн хувьд компани өнөөдрийн байдлаар 1.2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээгээд байна. Алдагдал үүссэн нөхцөл байдалд дан ганц компанийн үйл ажиллагаанаас бус дэлхий дахины цар тахлын нөхцөл байдал, бензин шатахуун, барилгын материалын үнийн өсөлт, ханшийн зөрүүний алдагдал, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өссөн, ндш-ийн хувь хэмжээ өссөн, төр засгийн шийдвэр хугацаандаа гардаггүй зэрэг хөндлөнгийн шалтгаанууд шууд нөлөөлдөг.

Мөн "Баянголын амны Бортолгойн дулааны өргөх нөсөс станц"-ын барилгын ажлыг 2014 онд 80 хувьтай гүйцэтгэсэн боловч үндсэн ажлуудыг дутуу хийсэн, цахилгааны тэжээлийг гол ячейканд холбоогүй, мөн туршилт тохируулгыг хийгээгүй, дулааны өргөх насос станцын программ хангамжийг угсарч суурилуулаагүй, дулааны шугамын дулаалга болон туршилт тохируулга зэрэг гол гол ажлууд хийгдээгүйгээс улсын комисс ажиллуулж чадахгүй байгаа ба тайлант хугацаанд үндсэн цахилгааны монтажны ажлын туршилт тохируулгыг гүйцэтгэж СХД-ийн ХҮТ-д хүлээлгэн өгч гэрээ байгуулав, мөн үндсэн барилгын ажлын гадна дотор засварууд, фундаметаараа цууралт өгч суусан зэргийг хүчитгэн гүйцэтгэв. Ажлууд дутуу хийгдсэн боловч санхүүжилтыг 2014 ондоо гүйцэд авсан тул компани өөрийн эх үүсвэрээс 2022 онд 71,8 сая төгрөгөөр дээрх ажлуудыг гүйцэтгэсэн. Одоо 300 /гурван зуу/ гаруй сая төгрөгийн ажил хийгдэхээр хүлээгдэж байна, гэхдээ Эрчим хүчний яамнаас авах санхүүжилт байхгүй, чанарын баталгааны мөнгийг хүртэл урьдчилаад 2014 онд бүгдийг авсан нөхцөл байдалтай байна.

Санхүүгийн үйл ажиллагааны хувьд 2021 онд компанийн удирдлагын зардлыг 204.6 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэл нь 87.7 сая төгрөг болж 126.9 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

Компанийн үл хөдлөх хөрөнгөд өөрчлөлт орж Чингэлтэй дүүргийн 6-р хороонд байрлах 424,3 сая төгрөгийн үнэлгээ бүхий 1960 онд баригдсан, конторын зориулалттай 2

давхар модон барилгыг ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн 2019 оны 07 дугаар сарын “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний дагуу “Сан” компанид шилжүүлж тус гэрээний дагуу оффисын зориулалттай 2 үл хөдлөх хөрөнгө, авто машины 3 зогсоолыг үл хөдлөх хөрөнгөдөө бүртгэж авсан. Энэхүү гэрээний дагуу манай компанид ирсэн үл хөдлөх хөрөнгийн борлуулалтаас “Чингис хаан банк”-ны үндсэн зээл зээлийн хүүгийн төлбөрт 250 /хоёр зуун тавин/ сая төгрөгийг харилцахаар, шүүхийн шийдвэрээр 640,8 сая төгрөгт тооцон талбай өгсөн, Г.Будгуайд 200 мкв талбайг дүйцүүлэн олгосон, мөн иргэн Ч.Оюунчимэгт шүүхийн шийдвэрийн дагуу 2014 оны ажлын зургийн төлбөрт 2 өрөө байрыг шилжүүлсэн, Тасганы ажлын автозамын нөхөн сэргээлт, сэтгэлгээний ажлын төлбөрт 301,226, 000 төгрөгийг, Тасганы ажлын автозамын 5 удаагийн сүвлэгээний ажлын төлбөрт 3 өрөө байрыг, мөн Тасганы ажлын гүйцэтгэлд зориулж 230 сая төгрөгийг мөн Хаан банкны зээлийн хүүнд 101 /нэг зуун нэг/ сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Мөн 2011 онд манай компанийн эзэмшлээс хасагдсан боловч баланс дээр бүртгэлтэй яваад байсан Баянгол дүүргийн 20-р хороонд байрлах 227,3 сая төгрөгийн үнэлгээ бүхий 45 машины гаражыг тайлант хугацаанд балансаас хасав.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 781.5 сая төгрөг байснаа оны эцэст 470.8 сая төгрөг болж өөрчлөгджээ.

Байгууллага хүмүүсээс авах авлага оны эхэнд 297.6 сая төгрөг байсан бол оны эцэст 921.2 сая төгрөг болж 623.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн Загийн усны хоолойн цэвэр усны шугам хоолойн төсөлд зориулан ган утсаар торлож хүчитгэсэн хуванцар хоолойг манай компани нийлүүлж байгаатай холбоотойгоор өссөн.

Мөн байгууллага хүмүүст өгөх өглөг оны эхэнд 1242.8 сая төгрөг байсан бол оны эцэст 842.8 сая төгрөг болж 400.0 сая төгрөгөөр буурсан байна.

Энэ онд улсын төсөвт төлөх НӨАТ, аж ахуйн нэгжийн ашгийн татвар, хүн амын орлогын татварт 14.8 сая төгрөг, мөн нийгмийн даатгалын шимтгэлд 29.8 сая төгрөг төлж татварын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байна.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: Гүйцэтгэх захирлын 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг сонслоо. Өнгөрсөн жилийн үйл ажиллагааг гүйцэтгэлийн хувьд “хангалттай” гэж ТУЗ дүгнэсэн. 2022 онд мөнгөн хөрөнгийн ашиглалт, банкны зээл төлөлт, зээлийн хүүг бууруулах болон авлага өглөгийг барагдуулах буюу эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд амжилттай ажилласан байна. Иймд санхүүгийн үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэсэн.

Гүйцэтгэх захирлын тайлантай холбоотой асуух зүйл байна уу?

Ц.Оргилболд: Тендерт оролцох боломжтой юу?

Б.Нарантуяа: Өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр, төлбөр ихтэй, алдагдлаа нөхөх боломж гарахгүй байгаа тул аливаа тендерт оролцох шалгуурыг хангахгүй байна. Ер нь төрийн худалдан авалтад оролцоход үнэлгээ маш доогуур, санхүүжилт их гацдаг зэргээс алдагдал үүсэх нөхцлүүд үүсч байна. Гэхдээ бид өөр гарц, боломж нөхцлийг судалж, БНХАУ-ын Шандонг мужийн “Тенюаны барилгын материал технологийн компани”-ийн

албан ёсны борлуулагчийн эрхийн хугацааг сунгаж худалдан авалт хийж эхэлсэн, мөн дэлхийд тэргүүлэх Израйлын брэнд “Бермад”-ын дилерийн эрх авахаар ажиллаж байна. Цаашид компанийн үйл ажиллагааг эко-инженерчлэл, технологийн дэвшилтэт тал руу нь чиглүүлж, зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажиллах зорилготой байгаа.

ХЭХ-ын дарга Б.Цогтгэрэл: За өөр асуулт байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудал 2023 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулах уу?

Гүйцэтгэх захирал Б.Нарантуяа 2023 оны төсөв, төлөвлөгөөг танилцуулав.

Хурлын дарга: Та бүхнээс энэ асуудалтай холбоотой асуух зүйл байна уу?

2023 оны төсөв төлөвлөгөөг батлах уу?

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ХЭХ-аас 2023 оны санхүүгийн төсвийг баталлаа.

Хурлын дарга Б.Цогтгэрэл: -Дараагийн хэлэлцэх асуудал ногдол ашгийн тухай. 2022 оны компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотойгоор ТУЗ-ийн 2023 оны 02 дүгээр сарын 09-ны өдрийн ТУ322/01 тоот тогтоолоор Ногдол ашиг тараахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

Шийдвэрлэсэн нь:

-Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэв.

- Компанийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэв

-Компанийн 2023 оны зорилт, төлөвлөгөөг батлах

-Компани 2022 онд Ногдол ашиг тараахгүй байх

Хурал 11.40 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

ХУРЛЫН ДАРГА

Б.ЦОГТГЭРЭЛ

Хурлын тэмдэглэл хөтөдсөн:

О.ОЮУНЖАРГАЛ